



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 10

Бор-Өндөр

Жонан дагдан Мажигхадлин хийдийн үйл
ажиллагаа явуулах зөвшөөрлийг сунгахыг
дэмжих тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг, тус тус үндэслэн Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Бумбат 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Жонан дагдан Мажигхадлин” нэртэй хийдийн тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчид хэлэлцээд 100 хувийн саналаар дэмжин цаашид үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд дэмжин хүргүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (О.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.
3. Жил бүр аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлан, танилцуулгаа тайлагнаж ажиллахыг Бор-Өндөр сумын иргэн, “Жонан дагдан Мажигхадлин” хийдийн удирдах зөвлөлийн дарга (Н.Мэндбаярт)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ